

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2026 оны 03 дугаар сарын 05

Дугаар БА-072/2026

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан, дунд төвөгшилтэй ангиллын зорьтой, 12 давхар 1 блок, 14 (арван дөрөв) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 64 (жаран дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2025.07.03 огноо, БАЗГ2023/930 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: КМ-18-40-258

2.3. Захиалагч: Дашгүнпанлин хийд оноосон нэр, 000012796 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9093559 регистрийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 38 дугаар хороо, 99997686 холбоо барих утас, Dashgunpanlinkhiid@yahoo.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: ЖАМО ХХК оноосон нэр, 9011223002 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2091534 регистрийн дугаар, БУ17-84/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 38 дугаар хороо, Хүнсчдийн гудамж, өөрийн байр, 99195794 холбоо барих утас, amarjargalnaidan90@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Анж андууд ХХК оноосон нэр, 901113009 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5192056 регистрийн дугаар, БУ12-488/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19 дүгээр хороо, Цайзын задгай 12-154 тоот, холбоо барих утас: 89205050, цахим хаяг: AnjAnduud50@yahoo.com

Хосбилэгт Наран ХХК оноосон нэр, 9011320020 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5534739 регистрийн дугаар, БУ19-556/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 9 дүгээр хороо, Дэнжийн 15-170 тоот, холбоо барих утас: 88119483, цахим хаяг: hosbiligtbaran@yahoo.com

Про салхивч комфорт ХХК оноосон нэр, 9011814338 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6517676 регистрийн дугаар, БУ12-44/25 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, 13 дугаар хороолол, 77-23 тоот, холбоо барих утас: 88049447, цахим хаяг: Prosalhivch123@gmail.com

Хашзэндмэнэ ХХК оноосон нэр, 9011075046 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2786966 регистрийн дугаар, МУ13-01/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, Ундрам эрдэнэ төвийн 01 тоот, холбоо барих утас: 99111571, цахим хаяг: ZendmeneBGD@gmail.com

Хөлөг элеватор ХХК оноосон нэр, 9011144002 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5206561 регистрийн дугаар, ӨБ16-456/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Их тойруу Логос төв, 1106 тоот, холбоо барих утас: 99903358, цахим хаяг: ch\_bmd@yahoo.com

Ундрам маргад ХХК оноосон нэр, 9011150127 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5978173 регистрийн дугаар, БУ11-658/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Орхоны 8-34 тоот, холбоо барих утас: 95500359, цахим хаяг: undrammargad@gmail.com

Өндөр түрүү ХХК оноосон нэр, 9011013021 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2854163 регистрийн дугаар, БУ11-365/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Шинэ хотхон хороолол 2-17 тоот, холбоо барих утас: 99990438, цахим хаяг: undurturuu99@gmail.com

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Криетив Монголиа ХХК оноосон нэр, 9011419094 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5726824 регистрийн дугаар, ЗТ11-313/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Их Монгол улсын гудамж, Санто Смарт апартамент 2-207 тоот 99114527 холбоо барих утас, sanjaa\_u@yahoo.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: ЖАМО ХХК оноосон нэр, 9011223002 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2091534 регистрийн дугаар, БУ17-84/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 38 дугаар хороо, Хүнсчдийн гудамж, өөрийн байр, 99195794 холбоо барих утас, amarjargalnaidan90@gmail.com цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Дашгүнпанлин хийдийн захиалгатай, Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан, дунд төвөгшилтэй ангиллын зорьтой, 12 давхар 1 блок, 14 (арван дөрөв) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 64 (жаран дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан, дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой, 12 давхар 1 блок, 14 (арван дөрөв) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 64 (жаран дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.


Дашгүнпанлин хийдийн захиалгатай,  
Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан,  
зоорьтой 12 давхар 1 блок, үйлчилгээтэй орон сууцны барилга

Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Захиалагч  
Дашгүнпанлин хийдийн тэргүүн



(Г.Удвал)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын  
үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БАТГАА  
Объект: 1086 05 1081 05  
Огноо: 05.08.2018  
Бүртгэсэн: О. Мунуу  
УЛААНБААТАР ХОТ ТТМ 1084

ДАШГҮНПАНЛИН ХИЙДИЙН ЗАХИАЛГАТАЙ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
38 ДУГААР ХОРООНД БАРИГДСАН, ЗООРЬТОЙ 12 ДАВХАР 1 БЛОК  
ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 01 дүгээр сарын 26

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗАР  
Улаанбаатар хот  
Барилга байгууламжийг ашиглалтанд  
оруулах комиссын хурал

Дашгүнпанлин хийдийн захиалгатай, Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан, дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой, 12 давхар 1 блок, 14 (арван дөрөв) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 64 (жаран дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын хурал 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт 15 гишүүний бүрэлдхүүнтэй эхэлж 10:30 цагт дуусав

Хуралд:

1. Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Хяналт шалгалтын газрын  
Барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтсийн  
Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтансүх
3. Хяналт шалгалтын газрын  
Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн  
Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч Э.Цогзолмаа
4. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн  
Техник хяналтын инженер Д.Гал-Эрдэнэ
5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн  
Баруун түгээх төвийн ахлах инженер Э.Ундрахцогт
6. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ийн  
О.Болорцэцэг
7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн  
Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн Н.Даваадэмид
8. Онцгой байдлын ерөнхий газрын  
Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан  
Ахлах мэргэжилтэн д/х М.Батсайхан
9. Барилгын хөгжлийн төвийн  
Барилгын чанар аюулгүй байдлын хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах
10. Үндэсний төв архив  
Зураг төслийн баримтын архивын архивч Н.Өлзийжаргал
11. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ  
ХҮТ-16 инженер Т.Батаа
12. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо,  
Хүртээмжийн үнэлгээний ажилтан Б.Ганбаатар
13. Зураг зохиогч байгууллага:  
Криетив Монголиа ХХК-ийн Б.Дэлгэрцогт

14. Гүйцэтгэгч байгууллага:

ЖАМО ХХК-ийн захирал

Н.Амаржаргал

15. Захиалагч:

Дашгүнпанлин хийдийн тэргүүн

Г.Удвал

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Дашгүнпанлин хийдийн захиалгатай, Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан, дунд төвөгшилтэй ангиллын зорьтой, 12 давхар 1 блок, 14 (арван дөрөв) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 64 (жаран дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилга угсралтын гүйцэтгэлийг хянаж дараах саналуудыг гаргав.

#### Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**


- БНБД-ийн 11-05-16 дагуу зохиогч дүгнэлт бичих, өөрчлөлттэй холбоотой зүйлсийг тусгах
- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6-н дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан бичгээр ирүүлэх
- Барилга байгууламжийн бетонтой холбоотой бичиг баримт шалгуулах
- Комиссын гишүүдийн үүрэг даалгавар биелүүлэх

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ц.Алтансүх**

- Батлагдсан зураг төсөл магадлалын дүгнэлт шалгуулах /захиалагч, зохиогч, гүйцэтгэгч нар тайлбар ирүүлэх
- Өөрчлөлтийн зураг төслийг баталгаажуулсан эсэх, баримтыг шалгуулах
- Дутуу орхигдсон заслын ажлыг гүйцээх
- Барилгын чанарт баталгаа гаргаж ирүүлэх
- Тохижилт, тоглоомын талбайн ажлыг гүйцээх талаар график төлөвлөгөө тайлбар ирүүлэх

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч **Э.Цогзолмаа**

- Гадна шугамын "Каркас" ХХК ийн зорийн давхраар түгээлтийн шугам явсанд ямар нэг гэмтэл гарвал бараа материал агуулахад гарсан хохирлыг хариуцах эсэхэд албан бичиг ирүүлэх
- Узелийн өрөөнд дутуу байгаа тоноглолыг суурилуулах /DPC хаалт, гуурс, ХХУ ны датчик, хими ус цэвэрлэгээний төхөөрөмж, ТАД ын дагуу хаягжуулах
- Өргөтгөл хийсэн болон гадна шугамын актыг хянагч байгууллагаар баталгаажуулж шалгуулах



- Барилгын дээвэр дээрх АС-ийн шахтыг цэвэрлэх
- Халуун хүйтэн усны тоолуурын коллекторын шугамыг бэхлэх, хаягжуулах
- Үйлчилгээний барилгын АС-ийн дуу чимээг хэмжиж шалгуулах
- Чанарын баталгаа албан тоот ирүүлэх

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер

#### **Д.Гал Эрдэнэ**

- Айл өрхөд УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг болон мэдээлэл цуглуулагч УБЦТС ТӨХК ХҮАТБ-с тодруулан акт үйлдэж актын дагуу суурилуулах
- Харьяа түгээх төвөөс хамгаалалтын зурвасын зөрчилгүй тодруулга авах
- Аянга болон ерөнхий шитний газардуулгын протокол нөхөж үзүүлэх
- Хүлээн авагч антенна суурилуулах
- 0.4 кВ шитэнд хаяг биркжүүлэлт хийх, АА-ны
- Ерөнхий шитэнд галын аюулгүй байдлыг хангах
- 0.4 кВ кабель шугамын мэдээллийн сангийн акт нөхөж үзүүлэх

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Баруун түгээх төвийн ахлах инженер

#### **Э.Ундрахцогт**

- 1-р хэлхээний шугам дутуу дулаалсан гүйцээж дулаалах
- DPCV-ний гуурс хийж ажилд оруулах
- Халуун хүйтэн усны тоолуурт бэхэлгээ хаягжуулалт хийх
- “Каркас” ХХК-с зоорийн давхараар 1-р хэлхээний шугам явуулахыг зөвшөөрсөн албан тоот авах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын **О.Болорцэцэг**

- Гадна шугам ажлын зургаас өөрчлөгдсөн тухай тайлбар бичиг /ган шугам/
- Гадна цэвэр усны худаг цэвэрлэх
- Нөөцийн саванд угаалга ариутгал хийх
- Удны уснаас дээж сорьц авч дүгнэлт гаргуулах /MNS 0900,2018/ стандарт хангах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна

Т ШАЛГ  
ГАЗАР  
ууламжий  
уулах ком

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн Улаанбаатар хотын сүлжээний газрын Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн

#### **Н.Даваадимэд**

- Холбоо дохиололын өрөөг хаягжуулах
- Давхарын самбаруудыг хаягжуулах
- Давхарын самбар дээрх кабель шугамуудыг цэгцэлж хаягжуулах
- Давхарын самбар дахь кабель шугамын залгаас холбоосуудыг стандарт хангаж холбох, залгааг сайжруулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай байна

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан Ахлах мэргэжилтэн, **д/х М.Батсайхан**

- Өөрчлөлтийн зураг төсөл хянуулах
- Гал унтраах автомат төхөөрөмж зоорийн давхарт хийх, дахин тооцоо хийж усны нөөцийн сав томруулах
- Барилгын гадна хананы дулаалга материалын гал тэсвэржилтийн зэрэг тогтоолгондүгнэлт үзүүлэх 2 материалаар
- Цахилгааны ерөнхий шитний өрөөнд бие даасан гал унтраах автомат төхөөрөмж суурилуулах, галын дохиолол мэдээлэгч хийх
- ГК гал унтраах дотор усны даралтат цэгийг даралттай усаар хангах
- Галын дохиолол мэдээлэгчийг 24 цагаар хүн байрлах өрөө тасалгаанд байрлуулах

Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материал үйлдвэрлэл, баталгаажуулалтын хэлтсийн Норм, нормативын сан бүрдүүлэлтийн мэргэжилтэ

#### **О.Ундрах**

- Дотор өрлөгөн ханын хаалганы проёмд зориулалтын ялуу хэрэглээгүй зохиогч байгууллагаар тайлбар албан бичиг ирүүлэх
- А, В, Д сууцны тагтны консоль нэмэгдсэнд тооцоо хийлгэж тайлбар албан бичиг ирүүлэх /зохиогч/
- Мөн цонх 3 давхар шилтэй гэж заасан боловч 2 давхар хийсэн дулаан техникийн тооцоо гаргаж тайлбар албан бичиг ирүүлэх /зохиогч/
- Суурь, В1, 2-р давхаруудад бетоны бат бэх дээр хөндлөнгийн байгууллагын дүгнэлт гаргуулах
- Техникийн давхар болон өөрчлөлт орсон хэсгүүдэд өөрчлөлтийн зураг гаргаж эрх бүхий байгуулгуудаар хянуулах
- БТХуулийн 5.7.1 заасны дагуу норм нормативийн төлбөрийг тооцуулан төлөх

Үндэсний Төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч

#### **Н.Өлзийжаргал**

- БУА-г гүйцэтгэсэн тэмдэглэлийг гүйцэтгэгч байгуулгаар батлуулах
- Хувийн хэрэг болон ил далд ажлын акт, гэрэл зураг, сертификатыг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлэх
- Баримт бичгийн хуудас дугаарлан дотоод товёог үйлдэж, эх хувийг архивт хүлээлгэн өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын ХҮТ-16 инженер

#### **Т.Батаа**

- Дулааны узельд халаалт ХХУ-ны бойлер буцах шугамд температурын датчик суурилуулах
- Халаалтын насост давтамж бууруулагч суурилуулах
- PPCV хаалтны суурь хийх

Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар**

- Нийтийн авто зогсоолд ХБИ-ний автомашинд зориулсан зогсоолын орцны хаалганы хамгийн ойр зогсоолыг төлөвлөх машины зогсоолын зай 2.4 м тэргэнцэртэй хүн бууж суух зай 1.5м эрээн шугамаар тусгаарлаж өгнө зогсоолын урд 1.8 м өндөр шонтой 60х60 см логотой самбар байрлуулах;
- Үйлчилгээний зал, орц руу орсон замын 2 талд 65смөндөртэй баруул хийнэ. Бариулын диаметр 3см-с ихгүй байна.
- Явган зам дээр хийсэн хөтөч замын анхаар буюу зогс тэмдэглэгээг хөндлөнгөөр 90см болгох
- 1, 2 давхарын үйлчилгээний заалын дотор хаалгыг 80см-с багагүй болгон суултуур, угаалтуур, шээлтүүрт БНБД-ийн 31-23-22 норм дүрэмд нийцсэн туслах бариулыг суурилуулна.

Зураг зохиогч байгууллага: Криетив Монголиа ХХК-ийн **Б.Дэлгэрцогт**

- Дээврийн шахтны малгай эвдэрснийг засах
- Дотор засалд силикон, жижиг ажлуудыг бүрэн дуусгах
- Дээвэрлүү гарах шат хийх
- Гадна зогсоолын тэмдэглэгээ гүйцээх

Гүйцэтгэгч байгууллага: ЖАМО ХХК-ийн захирал **Н.Амаржаргал**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Захиалагч: Дашгүнпанлин хийдийн тэргүүн **Г.Удвал**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Дашгүнпанлин хийдийн захиалгатай, Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороонд баригдсан, дунд төвөгшилтэй ангиллын зорьтой, 12 давхар 1 блок, 14 (арван дөрөв) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 64 (жаран дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Тэмдэглэл хөтөлсөн:

Захиалагч  
Дашгүнпанлин хийдийн тэргүүн

